



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2019 оны 11 сарын 27 өдөр

Дугаар 115

Номгон

Г Сонгон шалгаруулах зөвлөлийн  
удирдагч томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 107 дахь заалт, “Орон нутгийн бизнес, хөдөө аж ахуйг дэмжих сангийн үйл явцыг зохицуулах журам”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Германы хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачилга хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар байгуулсан “Орон нутгийн бизнес, хөдөө аж ахуйг дэмжих сан”-д иргэд, аж ахуйн нэгжүүдээс ирүүлсэн төслийг “Сонгон шалгаруулах зөвлөл”-ийн удирдагчаар аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-г томилсугай.

2. “Орон нутгийн бизнес, хөдөө аж ахуйг дэмжих сан”-гийн сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдийг томилж, ирүүлсэн төслүүдийн хэрэгжих боломжит байдлыг харгалзан сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг журмын дагуу үнэн зөв, шударга зохион байгуулж, үр дүнг тайлагнахыг сонгон шалгаруулах зөвлөлийн удирдагч /Г.Батжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Г.Эрдэнэбат/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

1190305